

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 – 11
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	12 – 26

1.	<i>Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, дөрөв дэх хэлэлцүүлэг/</i>	13 – 17
2.	<i>Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	17 – 21
3.	<i>“Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	21 – 26

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 11 дүгээр сарын 12-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Х.Ганхуяг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 58.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 29 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Тасалсан: Н.Алтанхуяг, Ж.Баясгалан, Х.Булгантуяа, П.Сайнзориг, П.Мөнхтулга, Ч.Номин, Д.Пүрэвдаваа, Г.Тэмүүлэн, Да.Цогтбаатар, Д.Энхтүвшин.

Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, дөрөв дэх хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганбат, мөн яамны Хөрөнгө оруулалт, гадаад зээл, ашиглалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 72 дүгээр зүйлийн 72.1-д “Төсвийн төслийн дөрөв дэх хэлэлцүүлгээр Төсвийн байнгын хороо нэгдсэн хуралдааны гурав дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсвийн төсөлд нэмж тусган, шаардлагатай бол гишүүнээс гаргасан саналын дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг өөрчлөхгүй, агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр арга хэмжээний нэр, хүчин чадал, хэрэгжих хугацаа, байршилтай холбоотой залруулгыг хийж, төсвийн төслийн эцсийн хувилбарыг танилцуулгын хамт нэгдсэн хуралдаанд оруулна.” гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүд болон ажлын хэсгээс гаргасан саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Х.Ганхуяг: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Нийслэлийн түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд унадаг дугуй, скүтэрийн гүүрэн тусгай зам барих техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар/;

Нийслэлийн түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд унадаг дугуй, скүтэрийн гүүрэн тусгай зам барих ТЭЗҮ, зураг төсөв;

Улаанбаатар гэж байршил зааж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16

Татгалзсан: 1

Бүгд: 17

94.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан гишүүн, Р.Сэддорж, Ц.Мөнхбат, Г.Ганбаатар, Р.Эрдэнэбүрэн нарын гаргасан, Онги-Цагаан бургастай төсөл, төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Өвөрхангай, Уянга, Зүүнбаян-Улаан сум, Өмнөговь, Мандал-Овоо сум, Улаан нуур/;

Онги-Цагаан бургастай төсөл, төслийн ТЭЗҮ, зураг төсөв;

/Өвөрхангай, Уянга, Зүүнбаян-Улаан сум, Өмнөговь, Мандал-Овоо сум, Улаан нуур/ гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17

Татгалзсан: 0

Бүгд: 17

100 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулгын гаргасан, Цэцэрлэгийн барилга, 200 ор /Архангай, Эрдэнэбулган сум, 6 дугаар цэцэрлэг/;

Цэцэрлэгийн барилга, 200 суудал /Архангай, Эрдэнэбулган сум, 6 дугаар цэцэрлэг/;

Өөрчлөлт оруулах санал: 200 суудал гэснийг 200 ор гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16

Татгалзсан: 3

Бүгд: 19

84.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн гаргасан, Багтагын голын бетон гүүр, 120.01 у/м /Хөвсгөл, Улаан-Уул сум/;

Багтагын голын бетонон гүүр шинээр барих 120.01 у/м /Хөвсгөл, Улаан-Уул сум/;

"Шинээр барих" гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 3
Бүгд: 19
84.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн гаргасан, Соёлын төвийн барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий, Батширээт сум/;

Соёлын төвийн барилга, /Хэнтий, Батширээт сум/;

"Барилга" гэснийг "Барилгын нэмэлт санхүүжилт" гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 2
Бүгд: 19
89.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн гаргасан, Соёлын төвийн барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий, Цэнхэрмандал сум/;

Соёлын төвийн барилга, /Хэнтий Цэнхэрмандал сум/;

"Барилга" гэснийг "Барилгын нэмэлт санхүүжилт" гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 5
Бүгд: 19
73.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайханы гаргасан, "Саран хөхөө" театрын барилгын дуусгал, 700 суудал /Дорноговь, Сайншанд сум, 7 дугаар баг/;

Саран хөхөө дуулалт театр;

"театр" гэснийг "театрын барилгын дуусгал" гэж өөрчлөн, "700 суудал /Дорноговь, Сайншанд сум, 7 дугаар баг/" гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 2
Бүгд: 19

89.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Шинэ суурьшлын бүсийн дэд бүтэц /Архангай, Эрдэнэбулган сум/;

Шинэ суурьшлын бүсийн дэд бүтцийн ажил /Архангай, Эрдэнэбулган сум/;

"Дэд бүтцийн ажил" гэснийг "дэд бүтэц" гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16

Татгалзсан: 3

Бүгд: 19

84.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайханы гаргасан, 1000 айлын орон сууцны гадна инженерийн шугам, сүлжээ /Ховд, Жаргалант сум/;

1000 айлын орон сууцны гадна инженерийн шугам, сүлжээний ажил /Ховд, Жаргалант сум/;

"сүлжээний ажил" гэснийг "сүлжээ" гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18

Татгалзсан: 1

Бүгд: 19

94.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Өсвөрийн инженерүүдийн инновацын төвийн барилгын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар, Баянгол дүүрэг/;

Өсвөрийн инженерүүдийн инновацын төвийн барилгын ТЭЗҮ, зураг төсөв;

Улаанбаатар, Баянгол дүүрэг гэж байршил зааж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18

Татгалзсан: 1

Бүгд: 19

94.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Газрын тос боловсруулах үйлдвэрийн цахилгаан хангамжийн 110кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/35/10кВ-ын Ширээт дэд станц /Дорноговь, Алтанширээ сум/;

Газрын тос боловсруулах үйлдвэрийн цахилгаан хангамжийн 110кВ-ын ЦДАШ, 110/35/10кВ-ын Ширээт дэд станц;

Дорноговь, Алтанширээ сум гэж байршил зааж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18

Татгалзсан: 1

Бүгд: 19

94.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Нийслэлийн хүүхдийн сэргээн засах "Эрүүл үрс" төвийн барилгын үлдэгдэл санхүүжилт /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/;

Нийслэлийн хүүхдийн сэргээн засах "Эрүүл үрс" төвийн барилгын үлдэгдэл санхүүжилт;

Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг гэж байршил зааж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18

Татгалзсан: 1

Бүгд: 19

94.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайханы гаргасан, Эрүүл мэндийн төвийн барилга, 10 ор /Ховд, Ховд сум, 5 дугаар баг/;

Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн барилга 10 ор /Ховд, Ховд сум 5-р баг, Дунд ус/;

"Сум тосгоны" гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18

Татгалзсан: 1

Бүгд: 19

94.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганбат, мөн яамны Хөрөнгө оруулалт, гадаад зээл, ашиглалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт С.Тэгшжаргал байлцав.

Монгол Улсын 2026 онд Төсвийн тухай хуулийн хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д “нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзвэл Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулахдаа санал хураалт явуулж болно.” гэж заасны дагуу санал хураалт явуулав.

Х.Ганхуяг: Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 5 дахь заалтын “хэлцэл, тэдгээрийг байгуулахад зөвшөөрсөн, дэмжсэн, төрийн нууцад авсан, холбогдох бүх шийдвэрийг” гэснийг “хэлцлийг” гэж өөрчлөх саналыг дахин хураалгах нь зүйтэй гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	15
Татгалзсан:	4
Бүгд:	19
78.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.	

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д “нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон

гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай...” гэж заасны дагуу санал хураалт явуулав.

Х.Ганхуяг: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, М.Бадамсүрэн, Ц.Баатархүү, Ж.Баясгалан, Б.Бейсен, Г.Лувсанжамц, З.Мэндсайхан, Д.Пүрэвдаваа, Д.Энхтүвшин /цаашид “ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дэх заалтын 5 дахь дэд заалтын “хэлцэл, тэдгээрийг байгуулахыг зөвшөөрсөн, дэмжсэн, төрийн нууцад авсан, холбогдох бүх шийдвэрийг” гэснийг “хэлцлийг” гэж өөрчлөх саналыг дахин хураалгах нь зүйтэй гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16

Татгалзсан: 3

Бүгд: 19

84.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганбат, мөн яамны Хөрөнгө оруулалт, гадаад зээл, ашиглалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал, С.Төрмөнх нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн гараагүй болно.

Х.Ганхуяг: Улсын Их Хурлын гишүүн. П.Ганзоригийн гаргасан, Монгол Улсын Их Хурлаас 2025 оны 11 сарын 12-ны өдөр баталсан Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийг Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн дээрх төслүүдтэй харьцуулж, Үндэсний аудитын газраас аудитын

дүгнэлт гаргуулж, 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Улсын Их Хуралд танилцуулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 5

Бүгд: 19

73.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Х.Ганхуяг: Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан,

1.Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны цалин хөлсийг үе шаттайгаар нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлэх.

2.Багш нарын мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагааг боловсруулж, салбарын шинэчлэл, сургалтын чанарыг сайжруулах, зорилттой уялдуулж, шинэ шатад хүргэх.

3.Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт англи хэлийг 3 дугаар ангиас оруулах болсонтой холбогдуулан стандартад нийцсэн сурах бичгээр хангах, сургалтын чанарыг сайжруулах, багш, боловсон хүчний нөөцийг бүрдүүлэх, дэд бүтэц, сургалтын орчны хүртээмжийг сайжруулах чиглэлээр шаардлагатай арга хэмжээ авч, хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх.

4.Монгол Улсын Засгийн газраас 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх” бодлогын хүрээнд дэвшүүлсэн “Үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх, эрдэм боловсролтой монгол хүн” бэлтгэх бодлогын хүрээнд Монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч хүмүүжлийг олгох зорилтуудыг ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт бүрэн цогц байдлаар системтэйгээр тусган хэрэгжүүлэх.

5.Мэргэжлийн болон техникийн боловсролын тогтолцоонд төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмыг нэвтрүүлэх, хөрөнгө оруулалт татах, хамтарсан сургалт, үйлдвэрлэл, судалгааны төв байгуулах замаар сургалтын орчныг сайжруулах, сургалтын тэтгэлэг, урамшууллын шинэлэг менежмент нэвтрүүлэх.

6.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хөдөлмөрийн шинэчлэл хийх, сургалтын байгууллагуудын менежментийн чадавхыг бэхжүүлэх.

7.Эрдэм шинжилгээ, судалгааны лаборатори, инновацын төвүүдийг үе шаттайгаар байгуулах, чадамжид суурилсан сургалтын хүртээмжийг нэмэгдүүлэх, суралцагчдын ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг өргөжүүлэх.

8.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нарын хөдөлмөрийн норм, нормативыг шинэчлэн тогтоох. Цалин хөлс урамшууллын бодлогыг боловсронгуй болгож, багшийн ажил, хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх.

9.Их дээд сургуулиудын санхүүгийн чадавх, биеэ даасан байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх.

10.Багш судлаачдын чадавхыг олон улсын түвшинд хүргэх, сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх, гадаадын өндөр ур чадвартай багш, мэргэжилтнийг урьж ажиллуулах чиглэлээр арга хэмжээ авах.

11.Түр болон богино хугацааны сургалтын байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналт, зохицуулалтыг сайжруулах зорилгоор тусгай зөвшөөрлийн эрх зүйн орчныг шинэчлэх, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх.

12.Түр сургалтын байгууллагын бүртгэл, хяналт, сургалтын агуулга, багшийн чадавх, үнэлгээний нэгдсэн системийг бий болгох, бодлого, зохицуулалт, хяналт хариуцсан бие даасан бүтэц, нэгжийг байгуулах.

13.Боловсрол дахь тэгш бус байдлыг арилгах, боловсролын чанарыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, боловсролын цахим шилжилтийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, ширээ сандал, тавилга, тоног төхөөрөмж, багш бүрийг компьютержуулэх, хүүхдийн авьяасыг дэмжих, цахим системд суурилсан нэмэлт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчим болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн санхүүгийн түрээс хэлбэрээр зохион байгуулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 16
Бүгд: 19

15.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа “Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Х.Ганхуяг: Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 5
Бүгд: 19
73.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 33 минут үргэлжилж, 29 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 65.5 хувийн ирцтэйгээр 15 цаг 02 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Х.ГАНХУЯГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
14 цаг 29 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Х.Ганхуяг: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя.

Ж.Алдаржавхлан гишүүн, Р.Батболд гишүүн, Э.Болормаа гишүүн, Ц.Даваасүрэн гишүүн, Б.Түвшин гишүүн, Т.Аубакир гишүүн, Ж.Батжаргал гишүүн, П.Ганзориг гишүүн, Д.Батбаяр гишүүн, З.Мэндсайхан гишүүн, Б.Чойжилсүрэн гишүүн, Ж.Батсуурь гишүүн, П.Ганзориг гишүүн, З.Мэндсайхан гишүүн, Б.Чойжилсүрэн гишүүн, Гомбын Ганбаатар гишүүн нар хүрэлцэн ирснээр 58.6 хувьтайгаар 17 гишүүдийн ирцээр өнөөдрийн хурлыг эхлүүлъя.

Хуралдааны ирцийг танилцууллаа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 58.6 хувьтай бүрдсэн тул 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Та бүхэнд танилцуулъя. Гурван асуудал хэлэлцэнэ.

Нэг.Монгол Улсын 2026 онд төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 онд төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 онд төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 онд төсвийн тухай хуулийн төсөл. Дөрөв дэх хэлэлцүүлэг.

Хоёр.Монгол Улсын 2026 онд төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд. Эцсийн хэлэлцүүлэг.

Гурав.“Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Анхны хэлэлцүүлэг.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн байна уу? Алга байна. Тэгвэл хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай,
Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай,
Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай,
Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд
/Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн,
дөрөв дэх хэлэлцүүлэг/**

Нэг.Монгол Улсын 2026 онд төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 онд төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 онд Төсвийн тухай хуулийн төслүүдийн дөрөв дэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. /алх цохив/

Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганбат, Сангийн яамны Хөрөнгө оруулалт, гадаад зээл, ашиглалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн.

Нэгдсэн хуралдааны гурав дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсвийн төсөлд нэмж тусгасан эцсийн хувилбарыг Та бүхэнд тараасан байгаа.

Эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 72.1-д заасны дагуу хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг өөрчлөхгүй, агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр арга хэмжээний нэр, хүчин чадал, байршилтай холбоотой саналуудаар санал хураалт явуулна.

Хоёр санал байгаа. Гишүүд ээ, санал хураалтдаа бэлдээрэй.

Д.Батбаяр гишүүнийх ороогүй байна. Г.Ганбаатар гишүүн ороогүй байна. Д.Үүрийнтуяа гишүүн ороогүй байна шүү. Д.Батбаяр гишүүн ээ.

Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил.

1.Нийслэлийн түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд унадаг дугуй, скүтэрийн гүүрэн тусгай зам барих техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар/;

Хураалгасан: Нийслэлийн түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд унадаг дугуй, скүтэрийн гүүрэн тусгай зам барих ТЭЗҮ, зураг төсөв;

Өөрчлөлт оруулах санал: Улаанбаатар гэж байршил зааж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал. Санал хураалт. /алх цохив/

17 гишүүнээс 16 гишүүн дэмжиж, 94.1 хувиар санал дэмжигдлээ. /алх цохив/

2.Онги-Цагаан бургастай төсөл, төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Өвөрхангай, Уянга, Зүүнбаян-Улаан сум, Өмнөговь, Мандал-Овоо сум, Улаан нуур/;

Хураалгасан: Онги-Цагаан бургастай төсөл, төслийн ТЭЗҮ, зураг төсөв;

Өөрчлөлт оруулах санал: /Өвөрхангай, Уянга, Зүүнбаян-Улаан сум, Өмнөговь, Мандал-Овоо сум, Улаан нуур/ гэж нэмэх.

Санал гаргасан Л.Мөнхбаясгалан гишүүн, Р.Сэддорж, Ц.Мөнхбат, Г.Ганбаатар, Р.Эрдэнэбүрэн. Санал хураалт. /алх цохив/

Санал дэмжигдлээ. 100 хувиар дэмжигдлээ. /алх цохив/

3.Цэцэрлэгийн барилга, 200 ор /Архангай, Эрдэнэбулган сум, 6 дугаар цэцэрлэг/;

Цэцэрлэгийн барилга, 200 суудал /Архангай, Эрдэнэбулган сум, 6 дугаар цэцэрлэг/;

Өөрчлөлт оруулах санал: 200 суудал гэснийг 200 ор гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулга. Санал хураалт. /алх цохив/

19 гишүүнээс 16 гишүүн дэмжиж, 84.0 хувиар санал дэмжигдлээ. /алх цохив/

4.Багтагын голын бетон гүүр, 120.01 у/м /Хөвсгөл, Улаан-Уул сум/;

Багтагын голын бетонон гүүр шинээр барих 120.01 у/м /Хөвсгөл, Улаан-Уул сум/;

"Шинээр барих" гэснийг хасах.

Санал гаргасан Б.Бат-Эрдэнэ гишүүн. Санал хураалт. /алх цохив/

84.2 хувиар санал дэмжигдлээ. /алх цохив/

5.Соёлын төвийн барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий, Батширээт сум/;

Соёлын төвийн барилга, /Хэнтий, Батширээт сум/;

"Барилга" гэснийг "Барилгын нэмэлт санхүүжилт" гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг. Санал хураалт. /алх цохив/

89.5 хувиар санал дэмжигдлээ. /алх цохив/

6.Соёлын төвийн барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий, Цэнхэрмандал сум/;

Соёлын төвийн барилга, /Хэнтий Цэнхэрмандал сум/;

"Барилга" гэснийг "Барилгын нэмэлт санхүүжилт" гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг. Санал хураалт. /алх цохив/

73.7 хувиар санал дэмжигдлээ. /алх цохив/

7."Саран хөхөө" театрын барилгын дуусгал, 700 суудал /Дорноговь, Сайншанд сум, 7 дугаар баг/;

Саран хөхөө дуулалт театр;

"театр" гэснийг "театрын барилгын дуусгал" гэж өөрчлөн, "700 суудал /Дорноговь, Сайншанд сум, 7 дугаар баг/" гэж нэмэх.

Санал гарсан Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан. Санал хураалт.

89.5 хувиар санал дэмжигдлээ. /алх цохив/

8.Шинэ суурьшлын бүсийн дэд бүтэц /Архангай, Эрдэнэбулган сум/;

Шинэ суурьшлын бүсийн дэд бүтцийн ажил /Архангай, Эрдэнэбулган сум/;

"Дэд бүтцийн ажил" гэснийг "дэд бүтэц" гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн. Санал хураалт. /алх цохив/

84.2 хувиар санал дэмжигдлээ. /алх цохив/

9.1000 айлын орон сууцны гадна инженерийн шугам, сүлжээ /Ховд, Жаргалант сум/;

1000 айлын орон сууцны гадна инженерийн шугам, сүлжээний ажил /Ховд, Жаргалант сум/;

"сүлжээний ажил" гэснийг "сүлжээ" гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан. Санал хураалт. /алх цохив/

94.7 хувиар санал дэмжигдлээ. /алх цохив/

10.Өсвөрийн инженерүүдийн инновацын төвийн барилгын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар, Баянгол дүүрэг/;

Өсвөрийн инженерүүдийн инновацын төвийн барилгын ТЭЗҮ, зураг төсөв;

Улаанбаатар, Баянгол дүүрэг гэж байршил зааж тусгах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал. Санал хураалт. /алх цохив/

94.7 хувиар санал дэмжигдлээ. /алх цохив/

11.Газрын тос боловсруулах үйлдвэрийн цахилгаан хангамжийн 110кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/35/10кВ-ын Ширээт дэд станц /Дорноговь, Алтанширээ сум/;

Газрын тос боловсруулах үйлдвэрийн цахилгаан хангамжийн 110кВ-ын ЦДАШ, 110/35/10кВ-ын Ширээт дэд станц;

Дорноговь, Алтанширээ сум гэж байршил зааж тусгах.

Санал гаргасан. Ажлын хэсэг Санал хураалт. /алх цохив/

94.7 хувиар санал дэмжигдлээ. /алх цохив/

12.Нийслэлийн хүүхдийн сэргээн засах "Эрүүл үрс" төвийн барилгын үлдэгдэл санхүүжилт /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/;

Нийслэлийн хүүхдийн сэргээн засах "Эрүүл үрс" төвийн барилгын үлдэгдэл санхүүжилт;

Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг гэж байршил зааж тусгах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж. Санал хураалт.
/алх цохив/

94.7 хувиар санал дэмжигдлээ. /алх цохив/

13.Эрүүл мэндийн төвийн барилга, 10 ор /Ховд, Ховд сум, 5 дугаар баг/;

Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн барилга 10 ор /Ховд, Ховд сум 5-р баг,
Дунд ус/;

"Сум тосгоны" гэснийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан. Санал хураалт.
/алх цохив/

94.7 хувиар санал дэмжигдлээ. /алх цохив/

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн дөрөв дэх хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн эцсийн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулах юм байна.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн дөрөв дэх хэлэлцүүлэг явуулж дууслаа. /алх цохив/

**Хоёр.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай
хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд
/Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн,
эцсийн хэлэлцүүлэг/**

Хоёр дахь асуудалдаа оръё.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсэг хэвээрээ. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн 2 хууль, Монгол Улсын Их Хурлын 2 тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг нэгдсэн хуралдаанаар явуулах үед олонхын

дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналыг хууль, тогтоолын төслүүдэд нэмж тусган, төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хувилбарыг Та бүхэнд тараасан байгаа.

Монгол Улсын 2026 онд Төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч Д.Үүрийнтуяа танилцуулна.

Д.Үүрийнтуяа гишүүнд микрофоноо өгье.

Д.Үүрийнтуяа: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 9 сарын 01-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улс Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн хамт өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2025 оны 11 сарын 07-ны өдрийн нэгдсэн чуулганаараа хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хорооны 2025 оны 22, 23 дугаар тогтоолуудаар байгуулагдсан ажлын хэсэг 2025 оны 11 сарын 11-ний өдөр хуралдаж, нэгдсэн хуралдаанаар гишүүдийн олонх дэмжсэн саналыг хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тусган, төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн бөгөөд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтад заасны дагуу нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 5 дахь заалтыг өөрчлөн найруулж, Тавантолгойн бүлэг ордтой холбоотойгоор байгуулсан, хэрэгжүүлсэн төрийн нууцад авсан гэрээ, хэлцлийг хууль тогтоомжийн дагуу төрийн нууцаас гаргах арга хэмжээг авч Улсын Их Хурал тайлагнах саналыг гаргаж байна.

Мөн Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-т заасны дагуу Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлд туссан зарим зохицуулалтын хэрэгжилтийг хангах үүднээс “Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан.

Энэ тогтоолын төслийн талаар танилцуулгыг оруулах уу, Байнгын хорооны дарга. Танилцуулаад явчих уу?

Х.Ганхуяг: Танилцуулаад явчих.

Д.Үүрийнтуяа: 3 дахь хэсэг дээр байгаа.

Тогтоолын төсөлд Монгол Улсын Засгийн газарт дараах асуудлаар зөвшөөрөл, үүрэг чиглэл өгөхөөр тусгалаа. Үүнд:

1.Өрийн удирдлагын тухай хуулийн 28¹.1 дүгээр зүйлийн 28¹.1 дэх хэсгийг үндэслэн нийслэл Улаанбаатар хотод тулгамдаад буй асуудлуудын санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор нийслэлийн дотоод үнэт цаас гаргах асуудлыг холбогдох хууль, бодлогын баримт бичигт нийцүүлэн шийдвэрлэх.

2.Боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны салбарын хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах, ажилтнуудын ур чадвар, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, иргэдэд үзүүлэх боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулиар багш, эмч, эрүүл мэндийн ажилтан, эрдэм шинжилгээний байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг нэмэгдүүлсэнтэй холбогдуулан төсвийн ерөнхийлөн захирагч нарын харьяа төсвийн байгууллагын үндсэн цалинг хуульд заасан хэмжээгээр нэмэгдүүлэх.

3.Төрийн албаны тогтолцоог шинэчлэн сайжруулж, хүний нөөцийн бодит үнэлэмж, бүтээмжийг нэмэгдүүлэх, салбар хооронд үүссэн цалин хөлсний тэгш бус байдлыг арилгах үүднээс төрийн албаны ангилал, зэрэглэлийг шинэчлэн, түүнтэй уялдуулан төрийн албан хаагчийн цалин хөлс, нэмэгдлийн асуудлыг оновчтой тогтоох эрх зүйн орчныг сайжруулах.

4.Төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, хөрөнгийг үр ашигтай ашиглах, төслүүдийн хэрэгжилтийн сахилга, хяналтыг сайжруулах үүднээс төсвийн хөрөнгө оруулалтаар эхэлсэн боловч дуусаагүй зогссон барилга байгууламж, төслүүдэд дүн шинжилгээ хийх, холбогдох арга хэмжээг авах.

5.Хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжлийг дэмжих, боловсролын орчныг сайжруулж, сургалтын чанар, тэгш хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор ерөнхий боловсролын 6-аас 12 дугаар ангийн нийт сурагчдад үдийн хоол хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын санхүүжилтийн эх үүсвэрийг судлан холбогдох эрх зүйн орчныг сайжруулж, 2027 оны төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авах саналыг төсөлд тусгасан болно.

Ажлын хэсэг Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, зарчмын зөрүүтэй саналын томьёолол болон Улсын Их Хурлын тогтоолын төслийг бэлтгэн Та бүхэнд тараасан болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, зарчмын зөрүүтэй саналын томьёолол болон Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Х.Ганхуяг: Д.Үүрийнтуяа гишүүн болон ажлын хэсэгт баярлалаа.

Хууль тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хувилбар болон ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Ажлын хэсгийн санал болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3-д нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзвэл Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулахдаа санал хураалт явуулж болно гэж заасны дагуу нэг санал хураалт явуулна.

Санал хураалтад бэлдээрэй. Гишүүд ээ.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 5 дахь заалтын “хэлцэл, тэдгээрийг байгуулахад зөвшөөрсөн, дэмжсэн, төрийн нууцад авсан, холбогдох бүх шийдвэрийг” гэснийг “хэлцлийг” гэж өөрчлөх саналыг дахин хураалгах нь зүйтэй гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Энэ саналыг хуралдаанд оролцсон гишүүдийг гуравны хоёроос доошгүй нь дэмжиж, байж санал дэмжигдэнэ. Санал хураалт. /алх цохив/

78.9 хувиар санал дэмжигдлээ.

Дээрх санал дэмжигдсэнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтад заасны дагуу санал хураалгах.

1.Төслийн 1 дэх заалтын 5 дахь дэд заалтын “хэлцэл, тэдгээрийг байгуулахыг зөвшөөрсөн, дэмжсэн, төрийн нууцад авсан, холбогдох бүх шийдвэрийг” гэснийг “хэлцлийг” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, М.Бадамсүрэн, Ц.Баатархүү, Ж.Баясгалан, Б.Бейсен, Г.Лувсанжамц, З.Мэндсайхан,

Д.Пүрэвдаваа, Д.Энхтүвшин. Цаашид “ажлын хэсэг” гэх. Санал хураалт. /алх цохив/

84.2 хувиар санал дэмжигдлээ.

Хууль тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг хэлэлцэж дууслаа.

**Гурав. “Монгол Улсын 2026 оны төсвийн тухай
хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай”
Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл
/Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/**

Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё.

Гурав. “Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-т “шаардлагатай гэж үзвэл Монгол Улсын жилийн төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арам хэмжээний тухай тогтоолыг энэ хуульд заасан хууль, тогтоолын төслийг хэлэлцэх журмын дагуу хэлэлцэн баталж болно.” гэж заасны дагуу “Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан Та бүхэнд тараасан.

Мөн тогтоолын төслийн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч Д.Үүрийнтуяа танилцуулсан.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа ажлын хэсэг хэвээрээ байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Горимын санал гаргаж байгаа юм байна.

Тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргаж байна. Бичгээр нэг горимын санал гаргасан байна. Хоёр санал ирсэн юм байна.

Монгол Улсын Их Хурлаас 2025 оны 11 сарын 12-ны өдөр баталсан Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийг Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн дээрх төслүүдтэй харьцуулж, Үндэсний аудитын газраас аудитын дүгнэлт гаргуулж, 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Улсын Их Хуралд танилцуулах.

Санал гаргасан Улсын Их Хурлын ХҮН намын зөвлөл, Улсын Их Хурлын гишүүн. П.Ганзориг.

Санал хураалтад нь бэлдье гишүүд ээ. Санал гаргасан гишүүн саналаа тайлбарлаж болно.

П.Ганзориг гишүүний микрофоныг өгье.

П.Ганзориг: Төсвийн байнгын хорооныхоо гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Тэгээд энэ санал маань болохоор 9 сарын 1-нд Засгийн газраас Их хуралд төсвөө өргөн барьдаг.

Тэгээд яг энэ хэлэлцүүлгийн явцад ажлын хэсэг болон Байнгын хороод дээр саналууд гараад нэлээн өөрчлөлтүүд ордог. Тэр хооронд ялангуяа тооцоо судалгаа багатай, нийгэм, эдийн засгийн үндэслэл, хөгжлийн бодлого, Засгийн газрын мөрийн хөтөлбөртэй уялдаа холбоотой зүйлүүд нь тодорхойгүй, эрэмбэ дараагүй төсөл, хөтөлбөрүүд нэлээд ордог асуудлууд байгаа. Та бүхэн бүгд мэдэж байгаа.

Одоо саяын 2026 оны төсөв дээр гэхэд 1.1 их наяд орчим төгрөгийн төсөл хөтөлбөр, арга хэмжээнүүдэд өөрчлөлтүүд орсон.

Тэгэхээр бид Засгийн газраас өргөн барьсан төсвийг Их Хурлаар хэлэлцээд батлахдаа өөрчлөлтүүд орж байгаа хоёр дээр харьцуулалт хийж үзмээр байгаа юм.

Тэгээд үүнийг Үндэсний аудитын газар бас харьцуулаад Их Хуралд эргээд тайлагнаач ээ.

- Яг энэ судалгаа тооцоо нь хэр байгаа юм.
- Эдийн засгийн үр өгөөж нь хэр байгаа юм.
- Эрэмбэ дараа нь хэр байгаа юм.

— Хуулийн нийцэл нь хэр байгаа юм гээд.

Тэгэхээр төсөв дагаад Их Хурлын тогтоол гарч байгаа дээр ийм заалт оруулж батлуулах санал оруулж байгаа юм.

Тэгээд Төсвийн байнгын хорооны гишүүдийг дэмжиж, өгөхийг хүсье. Баярлалаа.

Х.Ганхуяг: П.Ганзориг гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэснээр санал хураалт явагдана. Санал хураалт. /алх цохив/

73.7 хувиар санал дэмжигдлээ.

С.Зулпхар гишүүнээс ирүүлсэн саналыг Та бүхэнд уншиж танилцуулъя.

1.Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны цалин хөлсийг үе шаттайгаар нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлэх.

2.Багш нарын мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагааг боловсруулж, салбарын шинэчлэл, сургалтын чанарыг сайжруулах, зорилттой уялдуулж, шинэ шатад хүргэх.

3.Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт англи хэлийг 3 дугаар ангиасаа оруулах болсонтой холбогдуулан стандартад нийцсэн сурах бичгээр хангах, сургалтын чанарыг сайжруулах, багш, боловсон хүчний нөөцийг бүрдүүлэх, дэд бүтэц, сургалтын орчны хүртээмжийг сайжруулах чиглэлээр шаардлагатай арга хэмжээ авч, хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх.

4.Монгол Улсын Засгийн газраас 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх” бодлогын хүрээнд дэвшүүлсэн “Үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх, эрдэм боловсролтой монгол хүн” бэлтгэх бодлогын хүрээнд Монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч хүмүүжлийг олгох зорилтуудыг ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт бүрэн цогц байдлаар системтэйгээр тусган хэрэгжүүлэх.

5.Мэргэжлийн болон техникийн боловсролын тогтолцоонд төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмыг нэвтрүүлэх, хөрөнгө оруулалт татах, хамтарсан сургалт, үйлдвэрлэл, судалгааны төв байгуулах замаар сургалтын орчныг сайжруулах, сургалтын тэтгэлэг, урамшууллын шинэлэг менежмент нэвтрүүлэх.

6.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хөдөлмөрийн шинэчлэл хийх, сургалтын байгууллагуудын менежментийн чадавхыг бэхжүүлэх.

7.Эрдэм шинжилгээ, судалгааны лаборатори, инновацын төвүүдийг үе шаттайгаар байгуулах, чадамжид суурилсан сургалтын хүртээмжийг

нэмэгдүүлэх, суралцагчдын ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг өргөжүүлэх.

8.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нарын хөдөлмөрийн норм, нормативыг шинэчлэн тогтоох. Цалин хөлс урамшууллын бодлогыг боловсронгуй болгож, багшийн ажил, хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх.

9.Их дээд сургуулиудын санхүүгийн чадавх, биеэ даасан байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх.

10.Багш судлаачдын чадавхыг олон улсын түвшинд хүргэх, сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх, гадаадын өндөр ур чадвартай багш, мэргэжилтнийг урьж ажиллуулах чиглэлээр арга хэмжээ авах.

11.Түр болон богино хугацааны сургалтын байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналт, зохицуулалтыг сайжруулах зорилгоор тусгай зөвшөөрлийн эрх зүйн орчныг шинэчлэх, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх.

12.Түр сургалтын байгууллагын бүртгэл, хяналт, сургалтын агуулга, багшийн чадавх, үнэлгээний нэгдсэн системийг бий болгох, бодлого, зохицуулалт, хяналт хариуцсан бие даасан бүтэц, нэгжийг байгуулах.

13.Боловсрол дахь тэгш бус байдлыг арилгах, боловсролын чанарыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, боловсролын цахим шилжилтийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, ширээ сандал, тавилга, тоног төхөөрөмж, багш бүрийг компьютержуулэх, хүүхдийн авьяасыг дэмжих, цахим системд суурилсан нэмэлт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчим болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн санхүүгийн түрээс хэлбэрээр зохион байгуулах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтыг зогсооё. Ажлын хэсгийн ахлагч Д.Үүрийнтуяа тайлбар хэлнэ.

Д.Үүрийнтуяа: С.Зулпхар гишүүний гаргасан горимын санал ажлын хэсэг дээр хэлэлцэгдээд ажлын хэсэг дэмжээгүй.

Энэ бол бүхэл бүтэн яг нэг тогтоол орж ирж байгаа юм. Тусдаа бие даасан тогтоол байхаар.

Тэгээд энэ бол төсөв дагасан хууль, эрх зүйн актад тавигдах Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.5-д заасан шаардлагыг хангахгүй байгаа. Өөрөөр хэлбэл төсвийн орлого, зарлагын нийт дүнд нөлөө үзүүлэхгүй.

Яг энэ “Боловсролын жил” болгож 2026 оныг зарласантай холбоотой дотоод зохион байгуулалтын шинжтэй энэ тогтоолыг дараа нь холбогдох мэргэжлийн Байнгын хороодоор оруулаад гаргах нь зүйтэй гэдэг үндэслэлээр хэлэлцэхээс бид татгалзсан байгаа.

Х.Ганхуяг: Санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/ Дэмжье гэсэн саналаар явж байгаа шүү. С.Зулпхар гишүүний гаргасан саналыг дэмжье гэдгээр санал хураалт явж байна.

15.8 хувиар санал дэмжигдсэнгүй.

Горимын санал гаргана. Д.Үүрийнтуяа гишүүний саналыг сонсьё.

Д.Үүрийнтуяа: 2026 оны төсвийг дагаж төсөв батлагдсантай холбоотой дагаж хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр горимын санал гаргаж байна.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг эцсийн хэлэлцүүлгийг хамтад нь хэлэлцүүлж өгөөч ээ гэсэн горимын санал гаргаж байна. Санал хурааж өгнө үү.

Х.Ганхуяг: Д.Үүрийнтуяа гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулна.

Зарчмын зөрүүтэй санал гарчихаар чинь шууд явуулж болохгүй л дээ. Тийм. Уг нь яг ажлын хэсэг дээр саналаа оруулаад явчихгүй. Энэ чинь дахиад Байнгын хороо хуралдах болж байгаа байхгүй юу.

Тийм ээ, тийм. Тэгвэл цаашаа явъя.

Зарчмын санал гарсан болохоор саяын горимын санал хураагдахгүй гэсэн үг. Д.Үүрийнтуяа гишүүний микрофоныг өгчих.

Д.Үүрийнтуяа: П.Ганзориг гишүүний санал бол ажлын хэсэг дээр дэмжигдсэн санал юм.

Тэгээд Байнгын хороон дээр зарчмын зөрүүтэй саналуудыг бүгдийг нь дахиж санал хураалгадаг учраас сая санал хураалт явж байгаа. Түүнээс дэмжигдээгүй санал орж ирээд энд дэмжигдэж байгаа асуудал биш байгаа юм.

Тэгэхээр ажлын хэсгийн саналыг дэмжсэн учраас энэ асуудлыг хамтад нь явуулах боломж байх болов уу гэж хараад байгаа юм. Дэгийн зөвлөхүүд энэ дээр зөвлөж өгөөч.

Х.Ганхуяг: Ажлын хэсгийн санал руу П.Ганзориг гишүүний санал орсон бол П.Ганзориг гишүүн саналаа татаад уг нь цаашаа явах ёстой байсан юм. Тэгээд ороогүй байгаа болохоор тусад нь санал хураагдаад явж байна л даа.

Д.Үүрийнтуяа гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулж болно гэж манай дэг сахиулагч зөвлөх маань зөвлөлөө.

Тэгэхээр Д.Үүрийнтуяа гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя.

“73.7 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн талаарх Төсвийн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа нэгдсэн хуралдаанд танилцуулна.

“Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Төсвийн байнгын хорооноор хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 33 минут үргэлжилж, 15 цаг 02 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД